

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМД

2024 оны 12 сарын 04 өдөр

Улаанбаатар хот

**Хяналтын журмаар гомдол
гаргах тухай**

Гомдол гаргагч: Нэхэмжлэгч “Пропел” ХХК /РД:5193958/

Хариуцагч: Оюуны өмчийн газрын ахлах шинжээч О.Оюунгэрэл, ахлах
шинжээч Б.Оюунцэцэг, шинжээч Г.Буяндэлгэр, Б.Номиндарь

Гуравдагч этгээд: “Жаргалант Харвест” ХХК

Гомдлын шаардлага:

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 128/ШШ2024/0486 дугаартай шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 221/МА2024/0616 дугаар магадлалыг тус тус хүчингүй болгуулах тухай.

Гомдлын агуулга, үндэслэл:

Нэхэмжлэгч “Пропел” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Энхжин миний бие Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 128/ШШ2024/0486 дугаартай шийдвэрийг 2024 оны 07 дугаар сарын 18-ны өдөр гардан аваад, бүхэлд нь эс зөвшөөрч энэхүү гомдлыг гаргаж байна.

1. Анхан шатны шүүхийн шийдвэр хууль зүйн үндэслэлгүй тухайд:

1.1. Маргааны үйл баримтын тухай:

Нэхэмжлэгч нь 2008 оноос сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Оюуны өмчийн газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А/101 дүгээр тушаалаар Ө.Мөнхчулууны “Халбага шар тос” бүтээлд дүрслэх урлаг, уран баримал, график урлагийн бүх төрлийн бүтээл, эдгээрийн зураг төсөл төрлөөр зохиогчийн эрх олгосныг, уг эрхийн эзэмшигчээр “Пропел” ХХК-ийг бүртгэж, 13170 тоот Зохиогчийн эрхийн гэрчилгээ олгосон. Мөн газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/148 дугаар тушаалаар “Пропел” ХХК-ийн 30-2021-0004248 дугаартай мэдүүлэг бүхий “Халбаганд савлагаатай хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын загварт 2021 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн анхдагч огноотойгоор бүтээгдэхүүний загварын патент олгосон. Гэвч нэхэмжлэгчийн патентаар хамгаалагдсан бүтээгдэхүүнтэй давхцуулан гуравдагч этгээд болох “Жаргалант Харвест” ХХК-ийн 2021 оны 8 дугаар сарын 09-ний өдөр гаргасан патентын мэдүүлгийг Оюуны өмчийн газар хүлээн авч, шүүлт хийж байгаа талаар нэхэмжлэгч олж мэдсэн. Нэхэмжлэгч өөрийн зохиогчийн эрхийн гэрчилгээ болон патентаар хамгаалагдсан бүтээгдэхүүний загварын шийдлээ хамгаалж, Патентын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт заасны дагуу 30-2021-0004219 дугаартай патентын мэдүүлгийг тодорхой үндэслэлээр няцаан, 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Оюуны өмчийн газарт эсэргүүцэл гаргаж патент олгохгүй байхыг хүссэн.

Тус эсэргүүцлийг үндэслэн Оюуны өмчийн газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 23-ний өдрийн шинжээч томилох тухай А/96 дугаар тушаалаар хариуцагч ахлах шинжээч нар нь мэдүүлэгт дахин шүүлт хийж, 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн бүтээгдэхүүний загварын дахин шүүлтийн дүгнэлтээр нэхэмжлэгчийн эсэргүүцлийг үгүйсгэн, “Жаргалант Харвест” ХХК-ийн бүтээгдэхүүний загварт патент

олгох шийдвэр гаргасан. Нэхэмжлэгч Бүтээгдэхүүний загварын дахин шүүлтийн дүгнэлтийг 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр хүлээн авч танилцаад эс зөвшөөрч, Оюуны өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйл, Патентын тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу Аж үйлдвэрийн өмчийн эрхийн маргаан шийдвэрлэх зөвлөлд 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр гомдол гаргасан. Маргаан шийдвэрлэх зөвлөл нэхэмжлэгчийн гомдлыг хэлэлцээд 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 17 дугаар тогтоолоор гомдлын шаардлагыг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн. Нэхэмжлэгч нь Маргаан шийдвэрлэх зөвлөлийн тогтоолыг 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр хүлээн авч танилцаад эс зөвшөөрч, Оюуны өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дахь хэсэгт заасны дагуу шүүхэд нэхэмжлэл гаргасан.

1.2. Шүүхээс хийсэн дүгнэлтүүдийн тухай:

1.2.1 Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д “нэхэмжлэл” гэж хүн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд тусгайлан заасан бол захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг шийдвэрлүүлэхээр захиргааны хэргийн шүүхэд гаргасан өргөдлийг” гэж заасны дагуу зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан.

Патентын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т “Бүтээгдэхүүний загварын шийдэл нь анхдагч огноо, эсхүл давамгайлах огнооноос өмнө Монгол Улсад болон гадаад улсад нийтэд илэрхий болоогүй бол шинэ гэж үзнэ”, мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.4-д “Бүтээгдэхүүний загварыг, эсхүл түүнд хамаарах мэдээллийг зохион бүтээгч буюу мэдүүлэг гаргагч өөрөө, эсхүл уг мэдээллийг шууд буюу шууд бусаар олж авсан этгээд мэдүүлэг гаргагчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд илэрхий болгосон хэдий ч мэдүүлэг гаргах эрх бүхий этгээд тэрхүү өдрөөс хойш зургаан сарын дотор уг бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлгийг оюуны өмчийн байгууллагад гаргасан бол энэ нь шинэ гэх шалгуурыг үгүйсгэх нөхцөл болохгүй бөгөөд мэдүүлэг гаргагч үүнийг нотлох үүрэгтэй” гэж тус тус заасан байна.

Дээрх хуулийн заалтаас үзэхэд нэхэмжлэгч компанийн хувьд гуравдагч этгээд болох “Жаргалант Харвест” ХХК-ийн мэдүүлэг гаргасан хугацаанаас өмнө буюу 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Халбага шар тос гэсэн бүтээгдэхүүнээ худалдаанд гаргахаар Мэргэжлийн хяналтын газарт бүртгүүлж, мөн оны 06 дугаар сарын 02-ны өдөр Скай Хайпермаркет, И март, 2021 оны 06 дугаар сарын 23-ны өдөр Номин сүлжээ гэсэн байгууллагуудтай худалдааны гэрээ байгуулж 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс нийлүүлэлт хийгдэж, худалдаанд гарч, байгууллагын цахим хуудаст нийтлэгдсэн.

Түүнчлэн “Пропел” ХХК нь уг бүтээгдэхүүнийг загварыг нийтэд илэрхий болгосноос хойш 3 сарын дараа буюу 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлгийг Оюуны өмчийн газарт гаргасан.

Өөрөөр хэлбэл нэхэмжлэгч компанийн бүтээгдэхүүний загвар нь гуравдагч этгээд “Жаргалант Харвест” ХХК-ийн бүтээгдэхүүний загвараас цаг хугацааны хувьд

3 сарын өмнөөс нийтэд илэрхий болсон учраас “Пропел” ХХК-ийн бүтээгдэхүүн нь хуульд заасан шинэ гэх тодотголтой байхаар байна.

Мөн Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэгт мөн чанарын шүүлт хийх, нийтэд мэдээлэх, патент олгох, улсын бүртгэлд өөрчлөлт оруулах журмын 2 дугаар зүйлд “бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэгт шүүлт хийх”, 2.4-д “Бүтээгдэхүүний загварын “шинэ” гэсэн шалгуурыг хангаж байгаа эсэхийг Монгол улсад мэдүүлсэн болон эрхийн хамгаалалт хийгдсэн бүтээгдэхүүний загварын санд болон бусад хэвлэл мэдээллийн эх сурвалжид хайлт хийж, хайлтаар илэрсэн ижил төсөөтэй бүтээгдэхүүний загваруудтай жишиж харьцуулах аргаар шүүлт хийж, тогтооно” гэж заасан байна.

Гэтэл анхан шатны шүүхээс “...Нэхэмжлэгч хуулийн этгээдийн хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын загвар нь дээрх анхдагч огнооноос өмнө нийтийн хүртээл болсон, тус байгууллагын цахим хуудаст нийтлэгдсэн, худалдаалагдаж эхэлснийг үгүйсгэхээргүй боловч, бүтээгдэхүүний загварын давамгайлах огноо тогтоолгохтой холбоотой Патентын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан журмын дагуу гаргасан мэдүүлэг, хүсэлт, аливаа баримтыг шүүхэд гаргаж ирүүлээгүй. Иймд нэхэмжлэгч талын “...гуравдагч этгээдийн бүтээгдэхүүн нь шинэ байх/манай бүтээгдэхүүн нийтэд илэрхий болсон/ хуулийн шаардлага хангаагүй...” гэх агуулга бүхий тайлбарыг хүлээж авах үндэслэлгүй” гэж хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн. Түүнчлэн нэхэмжлэгчийн зүгээс мэдүүлэг хүсэлттэй холбоотой баримтыг гаргаж өгсөн бөгөөд мөн хавтаст хэрэгт хариуцагч байгууллагын зүгээс ирүүлсэн байгааг анхан шатны шүүх бүрэн гүйцэт үнэлж, дүгнэлт хийгээгүй гэж үзэхээр байна.

1.2.2 Анхан шатны шүүхийн шийдвэрийн “Үндэслэх” хэсгийн 8-д “...Оюуны өмчийн шинжээч нарын гаргасан “Бүтээгдэхүүний загварын шүүлтийн болон дахин шүүлтийн дүгнэлт”-үүдээр “Жаргалант Харвест” ХХК-д 30-2021-0004219 мэдүүлгийн дугаар бүхий патент олгохоор шийдвэрлэснийг хууль бус гэж үзэх үндэслэлгүй, учир нь Патентын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5-д “Дэвшүүлж байгаа шинэ бүтээлийн шийдэл нь энэ хуулийн 5, 6, 7 дугаар зүйлд заасан шалгуурыг хангасан бол мөн чанарын шүүлтийн тайланг шинжээчийн дүгнэлтийн хамт мэдүүлэг гаргагчид хүргүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор оюуны өмчийн байгууллага шинэ бүтээлийн ном зүй, товч тайлбар, тодорхойлолт, томъёоллыг албан ёсны тогтмол хэвлэлд нийтэлнэ”... гэж дүгнэсэн байх боловч Патентын тухай хуулийн 25 дугаар зүйл нь “Шинэ бүтээл”-д патент олгохоор зохицуулсан заалт юм. Өөрөөр хэлбэл Патентын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.17-д “шинэ бүтээл” нь байгалийн хуульд тулгуурлан сэдэж, үндэслэлийг нь тодорхойлсон бүтээгдэхүүн, үйлдвэрлэх арга, ажиллагаанд хамаарах техникийн шийдлийг” хэлнэ гэж заасан бөгөөд энэ нь бүтээгдэхүүний загвараас ялгаатай байхад хуулийн буруу заалтыг үндэслэл болгож шүүхийн шийдвэрийг гаргасан байна.

1.2.3 Мөн Патентын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “Энэ хуулийн зорилт нь шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварт патент олгох, зохион бүтээгч, патент эзэмшигчийн эрхийг хамгаалах, патентаар хамгаалагдсан шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварыг ашиглахтай холбогдсон

харилцааг зохицуулж, шинийг санаачлах үйл ажиллагаа болон аж үйлдвэрийн хөгжлийг дэмжихэд оршино” гэж заасан байна.

Бүтээгдэхүүний загвар нь иргэн, хуулийн этгээд өөрийн бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэх ялгагдах чадвартай илэрхийлэл-ийг ойлгохоор хуульд заасан, өөрөөр хэлбэл, ноос, ноолуур, зөгийн бал, сүү гэх мэтээр бараа бүтээгдэхүүний өөрийн бусдаас ялгагдах нэр нь бүтээгдэхүүний загвар биш, харин тэдгээрийг үйлдвэрлэгч, зах зээлд борлуулагчийн бусдаас ялгагдах зорилгоор зохиосон ялгагдах чадвартай илэрхийлэл нь бүтээгдэхүүний загвар болно. Гэтэл гуравдагч этгээд “Жаргалант харвест” ХХК нь “Халбага шар тос” нэртэйгээр өнгө зураглалын хувьд ижил бүтээгдэхүүн зарж, борлуулж байгаа нь хэрэглэгчийг төөрөгдүүлж, бүтээгдэхүүний патент эзэмшигчийн эрхийг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй, бусад этгээд ижил төрлийн бүтээгдэхүүн худалдан борлуулсан нь тус компанийн онцгой эрхээр хамгаалагдсан суурь өнгө зураглалын бүхий илэрхийлэл болох барааны тэмдгийн эрхийг зөрчиж байна гэж үзэхээр байна.

1.3. Шүүх нотлох зарчмыг бүрэн хэрэгжүүлээгүй тухай:

Хэрэгт авагдсан нотлох баримтаас харахад Патентын тухай хуульд заасан патент олгох шалгуур хангасан эсэхийг тогтоох дахин шүүлтийн дүгнэлт анхны шинжээчийн хийсэн шүүлтийн дүгнэлттэй ижил буюу тухайн хоёр компанийн сав баглаа боодлын загварууд тус тусдаа ялгарах шинж агуулсан, бие даасан, нэг нэгнийгээ хуулбарлан дуурайсан шинж үгүй, өөр өөрсдийн өнгө дизайн шийдлүүдээр ялгаатай, сав баглаа боодлын загвар байна хэмээн дүгнэсэн.

Захиргааны ерөнхий хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д “Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай нотлох баримтыг захиргааны байгууллага дараах байдлаар цуглуулна”, 25.1.3-д “шинжээч оролцуулан дүгнэлт гаргуулах, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д “Хэрэг хянан шийдвэрлэхэд шинжлэх ухаан, тооцоо, тоо бүртгэл, урлаг, утга зохиол, техникийн зэрэг тусгай мэдлэг шаардагдах асуудлыг тодруулахын тулд хэргийн оролцогчийн хүсэлтээр, эсхүл шүүхийн санаачилгаар шинжээчийг томилж болно” заасан. Гэтэл шүүхийн зүгээс тусгай мэдлэг бүхий шинжээчийг оролцуулахгүйгээр хариуцагчаар өөрөөр нь маргаан бүхий дүгнэлтийг нотлуулж, зөрүүтэй байдлыг тодруулах ажиллагааг хийлгүйгээр хэргийг хянан шийдвэрлэснийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Захиргааны хэргийн шүүх хэргийн нөхцөл байдлыг тодруулах, хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримт цуглуулах, үнэлэх ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд хэргийн оролцогчийг татан оролцуулна” гэж заасан шүүх нотлох зарчмыг хэрэгжүүлээгүй гэж үзэж байна.

НЭХЭМЖЛЭГЧИЙН

ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ

Д.ЭНХЖИН

